



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 22 өдөр

Дугаар АБЧ5

Арвайхээр

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.а, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.6, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 02/01 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “БҮТЭЭЛЧ ӨВӨРХАНГАЙ–2020” хөтөлбөрийн 3.3.5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүгд найрамдах Турк улсад зохион байгуулагдах Зуун буудалт даамны дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох Батхуяг овогтой Лхагваторгохын замын зардалд 1000000 (нэг сая), Хараагүй иргэдийн дунд зохион байгуулах спортын их наадамд оролцох тамирчдын замын зардалд 680000 (зургаан зуун наян мянга) төгрөгийн дэмжлэг тус тус үзүүлсүгэй.

2. Дээрх арга хэмжээний зардал 1680000 (нэг сая зургаан зуун наян мянга) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн сангаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101209